



DPUB

Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл



Мэдээллийн эмхэтгэл №4

2017 он 12-р сар

СХД-ийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтсийн бүтээлч ажил!

2017.11.29



СХД-ийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтсийн хамт олон 5-р сард Дэд бүтцийн үнэлгээний семинар, 9-р сард Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-д хамрагдсаны үр дүнд “Өөрийн байгууллагыг хүртээмжтэй болгох” аян зохион байгуулжээ. Хэлтсийн албан хаагчид 6 багт хуваагдан 9-р сарын 27-ны өдрөөс 1 сарын хугацаанд налуу зам засах, бариул суурилуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автомашины зогсоол бий болгох, дохионы хэлний сургалт зохион байгуулах

зэрэг ажлуудыг өөрсдийн мөнгөөр хийж гүйцэтгэжээ. Үүдний хананд хэлтсийн албан хаагчдын өрөөний дугаарыг тэмдэглсэн самбар байршуулсан нь хэн ч харахад ойлгомжтой болсон байлаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоолын тэмдэглэгээ нь цас орсны улмаас харагдахгүй байгаа учраас үйлчлүүлэгчдийнхээ санал хүсэлтийн дагуу нэмэлт тэмдэглэгээ байршуулсан байна. Тус хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хариуцсан мэргэжилтэн Саранцэцэг “Зөвхөн ХБИ төдийгүй, бүх хүмүүс үйлчилгээ авахад ая тухтай орчин бүрдсэн. Цаашид ч гэсэн өөрсдийн чадах хэмжээнд хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллах болно” гэж өгүүлж байлаа. Төслийн зүгээс ч гэсэн өөр бусад олон байгууллагыг хүртээмжтэй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулах болно.



Сайн байцгаана уу, та бүхэнтэй энэ дугаараараа дахин уулзаж байгаадаа баяртай байна. Гадаа хасах 30 хэмийн жавар тачигнасан өвлийн улирал болжээ.

Өмнөх дугаарт НҮБ-д ажиллах зорилгоор Австралид суралцах болсон тухайгаа бичсэн бол энэ удаа магистрантурт хэрхэн элсэж орсон тухайгаа бичье. Би бакалаврын зэргээ математикийн чиглэлээр хамгаалсан болохоор Олон улсын харилцааны чиглэлээр магистрантурт элсэж орохын тулд эхлээд улс төр, эдийн засгийн чиглэлээр суралцах шаардлагатай гэж бодож байсан. Гэтэл Японы их сургуульд бакалаврын зэрэг хамгаалсан бол мэргэжил харгалзахгүйгээр магистрантурт шууд элсэж орох боломжтой байлаа. Энэ нь Азийн бусад орнуудтай харьцуулахад давуу тал болж өгсөн юм. Дээрээс нь 3 жил суралцана гэсэн сэтгэл зүйн бэлтгэлтэй очсон би магистрантурын хөтөлбөр нь 1 жил байсанд их гайхсан. Сургалтын төлбөрөө хэмнэж чадсан нь сайн зүйл болсон хэдий ч 1 жилийн хугацаанд НҮБ-д ажиллаж чадахуйц мэдлэг олж авч чадах эсэхтээ санаа зовниж байлаа. Өмнө нь Японы жижиг дунд үйлдвэрийн салбарт ажиллаж байсан би англи хэлийг хагас жил, магистрантурт 1 жил суралцаад НҮБ-д ажиллаж чадах болов уу??

Энэ эргэлзээ маань сургуульд элсэж орсны дараа тайлагдсан... (Үргэлжлэлийг дараагийн дугаарт...)

Япон улс дахь сургалт

2017.12.1



Япон улсад зохион байгуулагдах “Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх” сэдэвт сургалтанд оролцох хүмүүс 11-р сарын 28-ны өдөр төслийн оффист ирж, урьдчилсан сургалтанд хамрагдлаа. Сургалтанд оролцох хүмүүсийн ихэнхи нь ХБИ бөгөөд туслах ажилчдын хамт 12-р сарын 11-ний өдөр Япон улсыг зорино.



Япон дахь сургалтаас өмнө төслийн ахлах зөвлөх Чибэ “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, ер нь “Конвенц гэж юу вэ?” гэх мэт сэдвүүдээр хичээл заасан бөгөөд ихэнхи хүмүүсийн мэддэг юм шиг боловч сайн мэддэггүй ойлголтын талаар тайлбарлан Япон дахь сургалтын суурийг тавьж өглөө. Мөн ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газраас “архи тохируулан хэрэглэх”, “зөвшөөрөгдсөн газар л тамхи татах” гэх мэт Япон улсад байх үедээ анхаарах ёстой зүйлүүдийн талаар тайлбар хийлээ.

Дараа нь сургалтанд оролцогчид өгөгдсөн сэдвийн дагуу илтгэл тавьснаар 3 цагийн сургалт дууслаа. Сургалтанд оролцох бүх хүмүүстээ амжилт хүсье.



JICA DPUB фэйсбүүк хуудсанд LIKE дарж нэгдээрэй.

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **1006** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуучуудад зориулсан 3 дахь удаагийн сургалт

2017.11.27

Энэ удаагийн сургалтанд 60 орчим хүн оролцлоо. Өмнөх удаагийн хоёр сургалтаар Англи, Америкийн ХБИ-ийн хөдөлгөөнийг танилцуулсан бөгөөд энэ удаа Японы ХБИ-ийн хөдөлгөөний тухай лекц тавьлаа. Залуучууд маань тус хичээлээс олон зүйлийг ойлгосон гэдэгт найдаж байна.

Япон улсын ХБИ-ийн хөдөлгөөний түүхийг өгүүлэхэд “Аой шибано кай” байгууллагын үйл ажиллагаа зайлшгүй яригддаг. Тус ТББ-ыг тархины саажилттай иргэд байгуулсан бөгөөд евгеник үзэл /Eugenics/-ийг эсэргүүцэн, маш хүчтэй хөдөлгөөн, тэмцлийг өрнүүлж байсан. Тэдний үйл ажиллагаа Англи, Америкийн ХБИ-ийн хөдөлгөөнүүдээс илүү ахицтай байсан төдийгүй дараа дараагийн хөдөлгөөнүүдэд ч гэсэн нөлөөлөх томоохон



жишээ болсон юм.

Дараа нь Японы Бие даан амьдрах төв, бодлогын түвшин дэх ХБИ-ийн оролцооны талаар танилцууллаа. Сургалтанд оролцогчдоос Япон, Англи, Америкийн ХБИ-ийн хөдөлгөөний тухай хичээлүүдээс ямар сэдэв нь илүү их сэтгэлд үлдсэн бэ гэж асуухад “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар” гэж хариулж байлаа. Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголтыг олон хүн мэддэг юм шиг боловч яг үнэндээ тийм биш байдаг. Энэ ойлголтыг хөгжлийн бэрхшээлтэй залуучууд төдийгүй халамжийн чиглэлээр ажиллаж буй төрийн албан хаагчид, хөгжлийн бэрхшээлтэй лидерүүд ч гэсэн бүрэн ойлгох шаардлагатай. Хөгжингүй орнуудын жишээнээс харахад нийгмийн загвар, ХБИ-ийн эрхийн тухай ойлголт нийгэмд бүрэн дүүрэн хүрсэн цагт л ниигэм өөрчлөгдсөн байдаг. Тийм учраас Монголд ч гэсэн энэ ойлголтыг улам илүү түгээж дэлгэрүүлэх чиглэлээр ажиллах болно.



Дараагийн сургалт 1-р сарын 24-ний өдөр зохион байгуулагдах тул та бүхэн идэвхтэй оролцоорой.

Сонголын бэрхшээлтэй иргэдийн олимп буюу Дифлимкийн алтан медальт тамирчин Икүшима Масаюки төслийн ажилчидтай уулзлаа

2017.11.23

Монголын сонголын бэрхшээлтэй хүүхдүүдэд ширээний теннис заах зорилгоор Дифлимкийн алтан медальт тамирчин Икүшима Улаанбаатар хотод хүрэлцэн ирээд байна. Тэрээр Японы алдартай тамирчдын нэг ба Дифлимт тасралтгүй 6 удаа оролцож нийтдээ 18 алт, 3 мөнгөн медаль хүртжээ. Мөн цаашид өөрийн туршлага чадварыг бусадтай хуваалцан, Монголын ширээний теннисний олон тамирчдыг Дифлимт оролцуулах хүсэлтэйгээ илэрхийлж байлаа.

Гэвч дасгал сургуулилт хийх орчин хангалтгүй байгаа бөгөөд “Одоо байгаа 2 ширээн дээр нэмээд дор хаяж 2 ширээ авах шаардлагатай” хэмээн өгүүлж байлаа. Тэрээр бөмбөг, цохиур зэргийг боломжийнхоо хэмжээгээр Японоос авчирсан хэдий ч ширээг эндээс худалдаж авахаас өөр аргагүй байгаа юм. Манай төсөл техникийн хамтын ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч шаардлагатай байгаа мөнгийг цуглуулах ажилд туслах болно. Та бүхнийг ч гэсэн дэмжиж тусална аа гэдэгт найдаж байна.



МУБИС, Нийгмийн ажилтан бэлтгэж эхэлсний 20 жилийн ойн арга хэмжээний хүрээнд DET сургалтыг зохион байгууллаа

2017.11.29

Энэ жил МУБИС Нийгмийн ажилтан бэлтгэж эхэлсний 20 жилийн ой тохиож байна. Ойн арга хэмжээний хүрээнд 11-р сарын 20-ны долоо хоног буюу нийт 5 өдөр Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ыг зохион явууллаа. Сургалтанд нийгмийн ажилтны ангид суралцаж буй 1-4-р курсын 150 оюутан оролцсон бөгөөд “Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?”, “Юу хийх ёстой вэ?” гэсэн



асуудлын талаар ярилцлаа. Сургалтын үндсэн сургагч багшаар Гэрэлцэцэг (хөдөлгөөний бэрхшээл), Болороо (тархины саажилт) нар оролцлоо. Мөн сургагч багш Уянга (тархины саажилт), Мишээл (тархины саажилт) нар багуудын чиглүүлэгчээр хамтран оролцсон. Оюутнууд “Бэрхшээл нь ХБИ-д байдаг гэж бодож байсан”, “Сургууль доторх шат бэрхшээл юм байна” гэх мэтээр ярилцаж байлаа. Нийт 3 цагийн сургалтанд хамрагдсанаар тэдний бэрхшээлийн талаарх ойлголт нь өөрчлөгдсөн гэдэгт найдаж байна.

Дараагийн дугаарыг сонирхон уншина уу.



DPUB төслийн хамт олноос

Хаяг: Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5,

Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

Фэйсбүүк хуудас: <https://www.facebook.com/jicadpub>

Цахим хуудас: <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

И-мэйл: dpub.jica@gmail.com